



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 592

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 9 ширхэг 87,963,406.50 /наян долоон сая есөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун зургаан төгрөг тавин мөнгө/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батсүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг компанийн дансанд төвлөрүүлэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001148

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
598 дугаар тогтоолын хавсралт

"Ховд АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Асфальтобетон зүсэгч хөрөө FTR3302	2004	1	5,390,600.00	5,390,600.00	5,390,600.00	0.00
2	Гар индүү Сакай	2004	1	7,260,000.00	7,260,000.00	7,260,000.00	0.00
3	Компрессор	2004	1	19,420,500.00	19,420,500.00	19,420,500.00	0.00
4	Нягтруулагч FR 130	2004	1	4,358,400.00	4,358,400.00	4,358,400.00	0.00
5	Нүүдлийн сууц	2005	1	25,639,900.00	25,639,900.00	25,639,900.00	0.00
6	Цахилгаан станц	2004	1	16,247,900.00	16,247,900.00	16,247,900.00	0.00
7	Хувилагч машин Samsung	2011	1	222,306.50	222,306.50	222,306.50	0.00
8	Чиргүүл	2000	1	5,065,200.00	5,065,200.00	5,065,200.00	0.00
9	Чиргүүл	2006	1	4,358,600.00	4,358,600.00	4,358,600.00	0.00
	Нийт дүн		9		87,963,406.50 /наян долоон сая есөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун зургаан төгрөг тавин мөнгө/	87,963,406.50 /наян долоон сая есөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун зургаан төгрөг тавин мөнгө/	0.00